

АУДИТЫН КОД: САГ-2018/09/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл

Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Ичинхорлоо

Утас: 261740 Цахим хаяг: ichinkhorloosh@audit.gov.mn

Аудитор О.Баярмаа

Утас:261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn

Аудитор С.Отгонхорлоо

Утас:261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn

АГУУЛГА

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	7
3	АУДИТЫН ТАЙЛАН	9
3.1	Оршил.....	9
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	9
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	10
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
3.5	Дотоод аудит.....	11
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
3.7	Шилэн дансны мэдээлэл	12
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	13
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	13
3.9.1	Харьяа байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлуудыг дурьдвал:	13
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлуудыг дурьдвал:	14
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	15
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	16
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	16
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	16
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	16
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	18
4.1	Үндсэн хөрөнгийн талаар.....	19
4.2	Урсгал үйл ажиллагааны зардал	20
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	21
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	21
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	22
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	23
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	24
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	25
	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	26



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.04.25 № 1028

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.


Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\110.10.10.20\Bichig_Kheregi\Yavisan_Bichig\2018\0425SAG17.Docx



Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

3 АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Оршил

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй өөрийн харьяа байгууллагуудад үндсэн хөрөнгө шилжүүлсэн, шилжүүлсэн хөрөнгийг зарим байгууллагууд бүртгэж аваагүй, урсгал үйл ажиллагааны зардлаас хөрөнгө бэлтгэсэн зэрэг алдаа, зөрчлийг залруулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 9-өөс 2018 оны 4 дүгээр сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Ичинхорлоо, аудитор О.Баярмаа, С.Отгонхорлоо нар хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний статистикийн хорооны дарга 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 3 дугаар сарын 29-ны өдөр 03/276 дугаар албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.



3.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үндэсний статистикийн хороо нь улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэх зорилготой.

Үндэсний статистикийн хорооны дарга Статистикийн тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Тогтвортой хөгжлийн дэлхийн болон үндэсний түвшний шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, арга зүйг боловсруулах, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, мэдээллийг бүрдүүлэх ажлыг эхлүүлэх;
- Анхан шатны мэдээллийн хяналт шалгалтыг өргөжүүлэх, мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргах, үнэн бодит байдлыг дээшлүүлэх;
- Статистикийн үйл ажиллагааны ерөнхий стандарт загварыг нэвтрүүлж эхлэх;
- Статистикийн салбарт хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бэхжүүлэх;
- Статистикийн дүн шинжилгээний чадавхыг бэхжүүлэх, шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх;
- Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах;
- Монгол Улсын статистикийн салбарын олон болон хоёр талт хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх;
- Статистикийн салбарын чадавхыг бэхжүүлэх, төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах бодлого зэрэг болно.

Үндэсний статистикийн хорооны дарга дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Үндэсний статистикийн хорооны дарга нь тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 6 арга хэмжээ төлөвлөж тайлагнасан байна.

Төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар нэгтгэн харуулав. Тухайлбал,

- Албан ёсоор гаргах статистикийн мэдээ, тайлангийн нэр төрлөөр 290;
- Албан ёсны статистикийн мэдээ, тайлан 112100;
- Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тархаалт 45;
- Шинээр болон шинэчлэн сайжруулсан аргачлал, ангилал, статистикийн мэдээллийн санд суурилж эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгаа 20;
- Статистикийн тухай хуулийн дагуу хийсэн байвал зохих улсын хэмжээний статистик судалгаа 21 арга хэмжээ;
- Хүн ам, орон сууцны тооллогын 2010 оны дүнд суурилан нийслэл, 21 аймгийн хүн амын тоог насны бүлгээр шинэчлэх, үр дүнг тархаасан байхаар төлөвлөж тус тус хэрэгжүүлсэн байна.

Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн зорилго, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын

стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Үндэсний статистикийн хорооны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 3.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 8 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 3.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон, нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй нийцэж байгаа тул нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Үндэсний статистикийн хорооны Хяналт, шинжилгээ үнэлгээ, мониторингийн хэлтэс нь Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүргийг гүйцэтгэж байна.

Үндэсний статистикийн хорооны Хяналт, шинжилгээ үнэлгээ, мониторингийн хэлтэс нь Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах 3 зөвлөмж өгч ажиллажээ.

Хүснэгт №1. Үндэсний статистикийн хорооны Хяналт, шинжилгээ үнэлгээ, мониторингийн хэлтсийн Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт



Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	21	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	21	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	21	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	3
		Дүн (сая.төг)	-
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	3
		Дүн (сая.төг)	-
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо	-
		Дүн (сая.төг)	-

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны Хяналт, шинжилгээ үнэлгээ, мониторингийн хэлтсийн тайлан

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Үндэсний статистикийн хорооны даргын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх 6 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсвөөс 7,314,2 сая төгрөг, гадаад тусламжийн эх үүсвэрээс 979.5 сая төгрөгийн санхүүжилт авахаар батлагдсанаас, гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтээр 6,899.2 сая, гадаад тусламжийн эх үүсвэрээс 680.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Туслах үйл ажиллагааны орлого 6.0 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас 14.5 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 8,299.9 сая төгрөг, үүнээс урсгал зардалд 7,320.3 сая төгрөг, гадаад зээл тусламжаас санхүүжих зардалд 979.6 сая төгрөгийг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэлээр урсгал зардалд 7,357.5 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 429.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан ба нийт дүнгээрээ 93.8 хувийн /Улсын төсвийн санхүүжилт болон гадаад санхүүжилтээр хэрэгжих төслийн эх үүсвэр төлөвлөснөөс бага орж ирсэн тул 513.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсан/ биелэлттэй байна.


Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3, 54.5.4-т заасны дагуу тайланг бүрэн бэлтгээгүй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Үндэсний статистикийн хорооны дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Үндэсний статистикийн хороо нь өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт;
2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;
4. Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төрлийн гүйцэтгэл;
5. Санхүүгийн тайлан;
6. Байгууллагын батлагдсан төсөв;



7. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
8. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл;
9. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;
10. Худалдан авах ажиллагааны тайлан зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.


Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлуудыг дурьдвал:

Зөвлөмж өгөгдсөн асуудлын талаар

- Нийслэл дэх Статистикийн газар, Баянхонгор, Булган, Хэнтий аймаг дахь Статистикийн хэлтэс нь санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг буруу ангилан бүтгэсэн, цалингийн бүртгэлийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн, санхүүгийн үр дүнгийн тайлангийн зарлагад бараа материал актласны зардал буруу илэрхийлсэн, харилцах дансны журналын бичилтээр зарим гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй зардлын дансанд шууд бичилт хийсэн зэрэг 63.4 сая төгрөгийн алдаа гаргасан,
- Нийслэл дэх Статистикийн газар, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Орхон, Өмнөговь аймаг дахь Статистикийн хэлтэс нь ашиглалтанд байгаа хангамжийн материалыг зардлаар бүртгэсэн, хангамжийн зүйлсийг бөөн дүнгээр бүртгэсэн, мөн хөрөнгийн тооллогын комисс нь тооллогын бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу бүрэн хийгээгүй, 28.6 сая төгрөгийн бараа материалыг дутуу тоолсон,
- Нийслэл дэх Статистикийн газар, Орхон, Өмнөговь аймаг дахь Статистикийн хэлтэс нь анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан, бараа материалын няравын тайлан болон бэлэн мөнгөний кассын тайлан бэлтгэж тайлагнаагүй 3.2 сая төгрөгийн зөрчил гаргасан,
- Завхан аймаг дахь Статистикийн хэлтэс нь сахилгын шийтгэлтэй ажилтнуудад 0.5 сая төгрөгийн урамшуулал олгосон,
- Баянхонгор аймаг дахь Статистикийн хэлтэс шүүхийн шийдвэрээр ажилдаа буцаж орсон ажилтны ажилгүй байх хугацааны цалин болох 5.6 сая төгрөгийг Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын даргын шийдвэрээр цалингийн сангаас олгосон,
- Нийслэл дэх Статистикийн газар, Булган, Орхон, Ховд, Хөвсгөл аймаг дахь Статистикийн хэлтэс нь тайлант онд авлага өссөн, авлага, өглөгийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалингийн зардлыг дутуу тайлагнасан, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог холбогдох байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүйтэй холбоотой 3.4 сая төгрөгийн зөрчил үүссэн,
- Сэлэнгэ аймаг дахь Статистикийн хэлтэс нь баталгаажуулаагүй томилолтын тооцооны хуудсаар 0.2 сая төгрөгийн томилолтын зардлыг тооцож олгосон,



- Ховд, Хэнтий аймаг дахь Статистикийн хэлтэс нь Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд оруулаагүй, дутуу мэдээлсэн, хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймаг, нийслэл дэх ТАБ-аас дээрх байгууллагуудын холбогдох хууль тогтоомж зөрчсөн 104.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулах 20 зөвлөмж хүргүүлсэн байна.

Албан шаардлага өгөгдсөн асуудлын талаар:

- Говь-Алтай аймаг дахь Статистикийн хэлтэс байгууллагын даргын болон өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гараагүй байхад 2.5 сая төгрөгийн бараа материалыг Үндэсний статистикийн хороонд шилжүүлж данс бүртгэлээс хассан байна. Мөн хувь хүний орлогын албан татварыг 0.04 сая төгрөгөөр дутуу суутгаж тайлагнасан,
- Сэлэнгэ аймаг дахь Статистикийн хэлтэс судалгааны ажлаар сумдад ажилласан жолоочийн албан томилолтын хугацааг буруу тооцон баталгаажуулж 1.3 сая төгрөг илүү олгосон,
- Нийслэл дэх Статистикийн газрын эд хөрөнгийн тооллогын комисс нь тооллогыг холбогдох заавар журмын дагуу бүрэн хийгээгүй, 28.5 сая төгрөгийн бараа материалыг дутуу тоолсон. Өмнөх оны 0.1 сая төгрөгийн авлага, 0.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 0.7 сая төгрөгийн цалингийн зардлыг дутуу тайлагнаж нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн, санхүүгийн тайланд хувь хүний орлогын албан татварын авлага 0.2 сая төгрөгийг тусгаагүй, ашиглалтанд байгаа 1.2 сая төгрөгийн хангамжийн материалыг зардлаар бүртгэсэн, анхан шатны бүрдэл дутуу баримтаар бараа материалын тайланд 0.8 сая, мөнгөн хөрөнгийн тайланд 2.1 сая төгрөгийн ажил гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3.1, 72 дугаар зүйлийн 72.4.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17.1.1, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 2.1.4-т заасантай тус тус нийцэхгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Аймаг, нийслэл дэх ТАБ-аас дээрх 3 байгууллагад 37.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлуудыг дурьдвал:

1. Үндсэн хөрөнгийн талаар

- Тайлант онд Үндэсний статистикийн хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 13.0 сая төгрөгийн 9 нэр төрлийн компьютер тоног төхөөрөмжийг 5 аймагт зөвшөөрөлгүй шилжүүлсэн,
- Үндэсний статистикийн хорооноос Дорнод аймаг дахь Статистикийн хэлтэст 1.9 сая, Өвөрхангай аймаг дахь Статистикийн хэлтэст 1.7 сая, нийт 3.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн өгсөн боловч тус байгууллагууд бүртгэж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн



31.2-т “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 5.1-д “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаагүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн илрүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1-д заасныг мөрдөж ажиллах, харьяа байгууллагууд руу шилжүүлсэн хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэж авах, алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

2. Урсгал үйл ажиллагааны зардлын талаар

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 179.8 сая төгрөгийн ArcGIS Server-Газарзүйн програм, 29.8 сая төгрөгийн серверийн компьютер, нийт 209.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээд нь эд хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Мөн тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардал 210817-д “Гуравдагч этгээдээр хийлгэсэн эрдэм шинжилгээний ажил, судалгааны ажлын зардлыг энэ ангилалд бүртгэнэ” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

3. Бүртгэл тайлагналын талаар


- Тайлант онд акталсан тавилга эд хогшлын үлдэх өртөг 3.6 сая, харьяа байгууллагууд руу шилжүүлсэн компьютер, тоног төхөөрөмжийн элэгдлийн зөрүү 46.1 сая, нийт 49.7 сая төгрөгийн элэгдлийн зөрүүгээр гарз тооцоогүй,
- Тайлант онд 15.4 сая төгрөгийн бараа материал акталсны зардлыг Санхүүгийн үр дүнгийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд тусгасан,
- Нийслэл дэх Статистикийн газрын 34.6 сая төгрөгийн авлагыг Санхүүгийн нэгтгэсэн тайланд дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, УСНББОУС 1-ийн 27-д: “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

3.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар гадаад зээл тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн ижэнх төслүүдэд тус хорооны ажилтнууд оролцож ажилласан байна.



3.11 Завсрын аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, аудитын зарим чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд гадаад зээл тусламжаас санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрийн зарцуулалтад нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

3.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 539.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг нэгтгэж, баталгаажуулав.

Үүнээс, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон энэ хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 326.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 99.6 сая төгрөгийн алдааг залруулж, 226.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 2 зөвлөмж хүргүүллээ.

Аймаг, нийслэлийн ТАБ-ууд Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж 213.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 71.4 сая төгрөгийн алдааг залруулж, 37.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, 104.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 20 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 36.4 сая төгрөгийн алдааг залруулах 5 зөвлөмжийг 90.0 хувьтай биелүүлсэн байна. Албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа 171 нэр төрлийн 980.9 сая төгрөгийн анхны өртөгтэй, элэгдээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх талаар холбогдох байгууллагын зөвшөөрөл авч, бэлтгэл ажил хийгдэж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Үндэсний статистикийн хорооны даргын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01/422 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

3.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 11,570.4 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь 115.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлон баталгаажуулсан ба төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшин 11.9 сая төгрөгөөр буурсан.

Нэмэлт санхүүжилтийн орлогын 3,094.7 сая төгрөг нь гадаад төслийн санхүүжилтийн эх үүсвэр байгаа нь эрсдэл багатай гэж үзсэн учраас төлөвлөлтийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлтийг өөрчилсөн болно.

3.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн

сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 3.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, АДБОУС болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үндэсний статистикийн хорооны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

4.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

1. Тайлант онд Үндэсний статистикийн хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 13.0 сая төгрөгийн 9 нэр төрлийн компьютер тоног төхөөрөмжийг 5 аймагт зөвшөөрөлгүй шилжүүлсэн,
2. Үндэсний статистикийн хорооноос Дорнод аймаг дахь Статистикийн хэлтэст 1.9 сая, Өвөрхангай аймаг дахь Статистикийн хэлтэст 1.7 сая, нийт 3.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн өгсөн боловч тус байгууллагууд бүртгэж аваагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1-д заасныг мөрдөж ажиллах, харьяа байгууллагууд руу шилжүүлсэн хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэж авах, алдааг давтан гаргахгүй байх,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

1. Холбогдох хууль, эрх зүйн актууд зөрчигдөх,
2. Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх, хөрөнгө дутагдах,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

4.2 Урсгал үйл ажиллагааны зардал

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 179.8 сая төгрөгийн ArcGIS Server-Газарзүйн программ, 29.8 сая төгрөгийн серверийн компьютер, нийт 209.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,

Холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Холбогдох хууль, эрх зүйн актууд зөрчигдөх,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/мян.төг/	
БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	568,525.8	401,415.0
Мөнгөн хөрөнгө	267,527.3	67,232.3
Авлага	123,181.4	83,959.8
Урьдчилгаа	-	6,369.9
Бараа материал	177,817.1	243,853.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,784,604.6	1,611,307.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,784,604.6	1,611,307.6
Биет хөрөнгө	1,618,895.8	1,333,465.3
Биет бус хөрөнгө	165,708.8	277,842.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,353,130.4	2,012,722.6
НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,629.4	3,848.0
Богино хугацаат өр төлбөр	25,629.4	3,848.0
Урт хугацаат өр төлбөр		
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,327,501.0	2,008,874.6
Засгийн газрын хувь оролцоо	2,327,501.0	2,008,874.6
Засгийн газрын оруулсан капитал	2,327,501.0	2,008,874.6
Хуримтлагдсан үр дүн	2,327,501.0	2,008,874.6
Өмнөх үеийн үр дүн	-	2,330,855.1
Тайлант үеийн үр дүн	2,327,501.0	(321,980.5)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,353,130.4	2,012,722.6

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	6,329,148.6	11,300,454.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,682,547.4	909,328.0
Нийтлэг татварын бус орлого	2,290,041.4	229,295.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,290,041.4	229,295.5
Тусламжийн орлого	392,506.0	680,032.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,646,601.2	10,391,126.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,001,647.6	11,570,419.1
УРСГАЛ ЗАРДАЛ	4,001,647.6	11,570,419.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,868,495.9	10,924,871.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,477,328.5	3,616,363.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,120.6	386,269.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1,000.0
Хангамж, бараа материалын зардал	148,513.5	487,497.2
Нормативт зардал	-	182.0
Эд хогшил, урсгал засварын зардал	2,242.8	162,614.0
Томилолт, зочны зардал	87,670.7	854,340.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,356,671.2	4,250,446.0
Бараа үйлчилгээний бусад зардал	632,948.7	1,166,158.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	133,151.7	645,548.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг		18,635.2
Бусад урсгал шилжүүлэг	111,384.4	384,135.8
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,767.3	242,777.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	2,327,501.0	(269,964.7)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		(52,015.8)
НИЙТ ҮР ДҮН	2,327,501.0	(321,980.5)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧ
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,327,501.0		2,327,501.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Тайлант үеийн үр дүн			
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,327,501.0		2,327,501.0
2017 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,327,501.0		2,327,501.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,354.1		3,354.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,330,855.1		2,330,855.1
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
Тайлант үеийн үр дүн	(321,980.5)		(321,980.5)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,008,874.6		2,008,874.6

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,159,905.6	11,241,913.8
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	503,788.7	696,614.5
Нийтлэг татварын бус орлого	503,788.7	696,614.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,656,116.8	10,545,299.3
Улсын төвлөрсөн төсвөөс	2,445,794.2	7,141,589.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,200,807.0	3,366,900.8
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,515.7	36,809.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,889,878.3	11,221,466.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,889,878.3	11,221,466.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,638,525.2	10,423,365.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,379,326.8	3,702,162.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,905.1	375,322.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	1,000.0
Хангамж, бараа материалын зардал	147,774.6	454,272.7
Нормативт зардал	-	182.0
Эд хогшил, урсгал засварын зардал	97,256.7	314,275.1
Томилолт, зочны зардал	83,076.7	730,901.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,409,495.6	4,194,464.8
Бараа үйлчилгээний бусад зардал	367,689.8	650,784.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,353.0	798,101.5
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	18,635.2
Бусад урсгал шилжүүлэг	114,106.7	455,537.9
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	137,246.4	323,928.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	270,027.3	20,446.8
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,500.0	213,336.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,500.0	213,336.7
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,500.0	(213,336.7)
Бусад эх үүсвэр	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	7,405.2
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(7,405.2)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	267,527.3	(200,295.0)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	267,527.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	267,527.3	67,232.3

5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	ХУВЬ
	БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,299,858.2	7,786,651.7	513,206.5	93.82
УРСГАЛ ЗАРДАЛ	8,299,858.2	7,786,651.7	513,206.5	93.82
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,816,763.1	7,357,584.8	459,178.3	94.13
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,368,562.8	3,343,366.9	25,195.9	99.25
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	366,275.5	363,558.5	2,717.0	99.26
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	-	-
Хангамж, бараа материалын зардал	174,381.0	245,923.1	(71,542.1)	141.03
Нормативт зардал	-	-	-	-
Эд хогшил, урсгал засварын зардал	28,552.9	158,124.0	(129,571.1)	553.79
Томилолт, зочны зардал	41,985.3	41,889.6	95.7	99.77
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,309,759.2	2,625,686.1	684,073.1	79.33
Бараа үйлчилгээний бусад зардал	527,246.4	579,036.6	(51,790.2)	109.82
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	483,095.1	429,066.8	54,028.3	88.82
Засгийн газрын урсгал шилжүүлэг	18,635.2	18,635.2	-	100.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-	-
Засгийн газрын гадаад шилжүүлэг	18,635.2	18,635.2	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	464,459.9	410,431.6	54,028.3	88.37
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,299,858.2	7,593,761.9	706,096.3	91.49
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,314,269.8	6,899,240.7	415,029.1	94.33
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,000.0	14,488.6	(8,488.6)	241.48
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	979,588.4	680,032.6	299,555.8	69.42
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	267,527.3		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	67,232.3		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**